

Оюутнуудын эсээ бичилтэд өгсөн үнэлгээний дүн

С.Оюунцэцэг¹, М.Үзмээ¹, С.Нармандах¹, С.Наранчимэг¹

¹ АШУУИС, Био-Анагаахын сургууль, Харилцааны ур чадварын тэнхим

Цахим шуудан: narmandakh@mnums.edu.mn, Утас: 99148074

Түлхүүр үгс:

харилцаа, даалгавар, загвар, рубрик

Товч утга:

Үндэслэл: Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн зайлшгүй эзэмших ур чадварын нэг бол бичгийн харилцааны чадвар юм. Бичгийн харилцаанд өдөр тутмын тэмдэглэл, захидал, албан бичиг, хувийн өргөдөл, тойм мэдээлэл, тайлан, зохион бичлэг, эсээ зэрэг ордог. Эсээ нь оюутнуудын аливаа асуудалд оюун дүгнэлт хийх, тухайн нөхцөл байдлыг үнэлэх, мэдлэгийн хүрээ, ойлголцлыг үнэлэхэд ашигладаг бичгийн үнэлгээний хэлбэр бөгөөд эсээ бичих нь сэтгэн бодох, шүүмжлэлтэй сэтгэх, дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэх чухал арга хэрэгсэл болдог¹.

Зорилго: Суурь боловсролын I дамжааны оюутнуудын эсээг харьцуулан үнэлгээ өгөх

Арга, аргачлал: Уг судалгаагаар 2022–2023, 2023–2024 оны хичээлийн жилд Харилцааны ур чадварын хичээлийг судалсан оюутнуудын “Миний бага нас” сэдвээр бичсэн эсээг Рубрикийн 6 шалгуураар үнэлж, бүлгийн ярилцлагаар эсээ бичихэд оюутнуудад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон.

Үр дүн: 2022–2023 оны хичээлийн жилд суралцсан суурь боловсролын I дамжааны 568 оюутны эсээний 32.6% нь үг үсгийн алдаатай, 25.5% нь өгүүлбэр зүй, найруулгын алдаатай, 20.4% нь агуулгын хувьд хангалтгүй бичигдсэн байсан бол 2023–2024 оны хичээлийн жилд суралцсан 525 оюутны эсээний 28.6% нь үг үсгийн алдаатай, 21.8% нь найруулгын алдаатай, 18.6% нь агуулгын дутагдалтай эсээ бичсэн нь ажиглагдсан. Түүнчлэн 10.5% нь эсээ бичихэд шаарддаг эсээний бүтэцгүй байв.

Дүгнэлт: Цаашид оюутнуудын бичгийн ур чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн салбарт ажиллах ирээдүйн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бичгийн харилцааны чадварыг эзэмших нь зайлшгүй шаардлагатай. Эсээ бичих нь зөвхөн мэдээлэл дамжуулах бус, мэдээллийг боловсруулж, шүүмжлэлтэй сэтгэн бодох, дүгнэлт хийх, судалгаа хийх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зэрэг цогц чадваруудыг хөгжүүлдэг². Бичгийн харилцааны үндсэн хэлбэрүүдэд тэмдэглэл, захидал, албан бичиг, тайлан, зохион бичлэг, эсээ зэрэг ордог. Эсээ нь оюутнуудын мэдлэг, ойлголт, дүгнэлт, бичгийн чадварын үнэлгээний чухал хэлбэр болдог³. Иймд анагаах болон эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын бичгийн илэрхийллийг үнэлэх шаардлагатай байна.

Судлаач Д.Галбаатар: “Эсээ нь хүүрнэл/туульсын болон сэтгүүл зүй, судалгаа

шинжилгээний/зохиолын нэг зүйл гэжээ. Эсээ нь уран зохиолд ямар нэг шалтгаан хийгээд асуудлын талаар хувь уран бүтээлчийн бодол, эргэцүүлэмж, таамаглалыг шингээсэн юмс үзэгдлийн мөн чанар, шалтгаан холбоо хамаарлыг заавал бүрэн буюу гүйцэд илэрхийлсэн байх албагүй бэсрэг хэмжээтэй, чөлөөт уран сэтгэмж, чөлөөт зохиомжит үргэлжилсэн үгийн зохиолын бие даасан шинэ төрөл зүйл болж хөгжиж, бичлэгийн хэв маяг нь товч яруу дүрслэг шинжтэй байхаас гадна ярианы аялга, үгсийн сан, зорилгоороо ялгардаг. Эсээ гадаад хэлбэр, бичлэг, зохиомжийн хувьд сэтгүүл зүйн, агуулгын хувьд уран зохиолд хамруулж болохуйц бүтэцтэй байдаг”.

Судлаач Л.Түдэв: “Тодорхой сэдвийг зохиолч хэрхэн бясалган эргэцүүлж ямар дүгнэлтэд хүрснийгээ чөлөөтэйгөөр хүүрнэн өгүүлэх богино

хэлбэрийн зурвас өгүүлэл, найруулал, шүүмжийн аль алины шинж төрхийг агуулсан задгай зохиомжтой зохиол болон хэвшсэн байна” гэжээ.

Түүнчлэн судлаач М.Зулькафилъ “Эсээ бичигч тал бүрээс нь нарийвчлан судалж, түүнийг эрэмбэ, дэс дараалалтай нарийн логик холбоогоор үзүүлэхийг урьтал болгодоггүй, харин сонгож авсан сэдвээ нийгмийн хурц асуудлыг хөндөхөд чиглүүлж, түүнийгээ хувийн сэтгэгдэлтэй хослуулан бодол эргэцүүллийн маягаар гаргаж хэлэхийг гол зорилгоо болгодог” гэсэн байна.

Л. Норовсүрэн: “Эсээ бичигч аливаа үйл явдал, үзэгдлийг урнаар үзүүлэхийн тулд уран яруу найруулга, ярианы хэлийг ашиглан, элдэв баримт жишээг чөлөөтэй хэрэглэдэг байна. Эсээг шинжлэх ухаан, гоо зүй, ёс суртахуун, түүхийн аль ч сэдвээр бичлээ гэсэн гүн ухааны бясалгалын аяс нэвтэрхий байдаг нь түүний гол онцлог мөн” гэж дурьдсан байна.

Дээр дурдсанаас үзвэл эсээ нь дараах үндсэн шинжтэй байдаг.

- Өгүүлэл, найруулал, нийтлэл, шүүмжийн аль алины шинжийг агуулсан

- харьцангуй богино хэмжээтэй хүүрнэл хэлбэр

- Эсээ нь өөрийн нарийн тогтсон бүтэц, бүрэлдэхүүн хэсэгтэй, бичлэгийн тодорхой арга техниктэй сонгомол төрөл

- Эсээ нь загварт буюу мэргэжлийн, загварт бус буюу чөлөөт гэсэн хоёр өөр түвшинтэй.

Эсээ нь бичих зүйлийнхээ гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэр бүхий эхлэл хэсэг, түлхүүр өгүүлбэр болон эхлэл цогцолборт өгөгдсөн гол санааг лавшруулах дэмжих, нэмэн өргөжүүлэх мэдээллүүдийг агуулсан их бие, эсээнийхээ санааг нэгтгэн дүгнэх, гол санаагаа тайлах, уншигчдад эргэн сануулах зорилго бүхий төгсгөл гэсэн гурван хэсгээс бүрддэг байна. Иймд бид энэхүү судалгаагаар АШУУИС-д суралцаж буй оюутнуудын эсээ бичих чадварыг үнэлэх зорилго тавин ажиллаа.

Зорилго: Суурь боловсролын I дамжааны оюутнуудын эсээг харьцуулан үнэлгээ өгөх

Арга, аргачлал: Судалгааг агшингийн загвараар хийсэн бөгөөд судалгаанд 2022–2023 хичээлийн жилд АШУУИС-ийн Био-Анагаахын сургуульд суралцаж байсан суурь боловсролын I дамжааны 568 оюутны, 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байсан суурь боловсролын I дамжааны 525 оюутны “Миний багана” сэдэвт эсээг хамруулж үнэлгээг хийлээ. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа чанарын арга ашигласан. Үүндээ: эсээний бичилтийг үнэлэх Рубрикийн арга болон эсээ бичихэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх номиналь бүлгийн ярилцлагын арга ашигласан. Рубрикийг аргад дараах 6 шалгуурыг ашиглан хийсэн бөгөөд эдгээрт: 1) эхний өгүүлбэрийн

сонирхолтой байдал, 2) үг үсгийн алдаа, 3) найруулга зүй, 4) өгүүлбэрийн бүтэц, 5) агуулгын иж бүрдэл, 6) нотолгоо/ишлэл ашигласан эсэх зэргийг хамруулсан.

Номиналь бүлгийн ярилцлагад 12 оюутныг санамсаргүй түүврийн аргаар сонгож, эсээ бичихэд тулгарч буй бэрхшээл, дотоод ойлголт, хэрэгцээг илрүүлсэн.

Судалгааны үр дүнг боловсруулахдаа эсээ бичилтэд дескриптив боловсруулалт хийж бүлгийн ярилцлагын үр дүнг агуулгын хувьд нэгтгэн харууллаа.

Үр дүн: 2022–2023 оны хичээлийн жилд суралцаж байсан суурь боловсролын I дамжааны 568 оюутны эсээний 32.6% нь үг үсгийн алдаатай, 25.5% нь өгүүлбэр зүй, найруулгын алдаатай, 20.4% нь агуулгын хувьд хангалтгүй бичигдсэн байсан.

Харин 2023–2024 оны хичээлийн жилийн суурь боловсролын I дамжааны 525 оюутны эсээний эсээ бичилтийг Рубрикийн аргаар үнэлэхэд 28.6% нь 1-5 үг үсгийн алдаатай, 21.8% нь найруулгын алдаатай, 18.6% нь агуулгын хувьд дутуу бичигдсэн бөгөөд нотолгоо, эшлэл дутуу ашигласан байв. Мөн 10.5% нь эсээний үндсэн бүтцийн (эхлэл, өрнөл, төгсгөл) дутуу бичигдсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Оюутнуудын эсээ бичилтэд өгсөн үнэлгээ

Үзүүлэлтүүд	2022-2023(%)	2023-2024(%)
Үг, үсгийн алдаатай	32.6	28.6
Өгүүлбэр зүй, найруулгын алдаатай	25.5	21.8
Эсс эхлэл, өрнөл, төгсгөл дутуу	9.3	10.5
Агуулга хангалтгүй	20.4	18.6

Бүлгийн ярилцлагаар оюутнуудын дийлэнх нь эсээ бичих аргачлалын талаар тодорхой ойлголтгүй, бичгийн болон ярианы хэлний ялгаа мэдэхгүй, эсээ бичих загвар хараагүй, өөрийгөө бүрэн илэрхийлэхэд үгийн сонголт зөв хийх, найруулах, оновчтой байдлаар дараалуулах хүндрэлтэй байсан гэж хариулсан.

Хэлцэмж: Бичгийн харилцаа нь эрүүл мэндийн мэргэжилтний мэргэжлийн ёс зүйн салшгүй нэг хэсэг гэж олон судалгаанд онцолж байна. Сүүлийн жилүүдэд олон улсын судалгаагаар эрүүл мэндийн салбарын оюутнуудын бичгийн илэрхийлэх чадвар тулгамдсан асуудал байсаар буйг онцолж байна.

Судлаач Варкей нар 2009 онд анагаахын оюутнууд бичгийн харилцааны талаар хамгийн бага мэдлэгтэй эсвэл огт мэддэггүй болохыг дурдсан байна. Сайн бичсэн санал, төлөвлөгөө

нь эмч нарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багийн салшгүй нэг хэсэг бөгөөд гишүүдийн хувьд эрүүл мэндийн манлайллыг бий болгоход тусална гэжээ⁴. 2013 оны Симонсон нарын судалгаанд резидентүүд гараар бичсэн "баярлалаа" гэсэн тэмдэглэл, өдөр бүр цахим шуудан солилцох, эрүүл мэндийн цахим бүртгэл зэргийг албан ёсны бичгэн харилцаа гэж үздэг тухай дурдсан бөгөөд эмнэлгийн чиглэлээр суралцагчдын 38% нь бичгийн бүтэц, найруулгад холбогдох сургалтад хангалтгүй хамрагдаж байгааг илтгэсэн байна⁵.

Нөгөө талаас оюутнууд сургалтын үйл ажиллагаанд рубрик ашиглах нь хичээл зүтгэлээ төвлөрүүлж, чанартай ажил хийж, илүү сайн үнэлгээ авч, даалгаврын талаар бага санаа зовоход тусалдаг гэжээ⁶.

Манай судалгааны дүн нь Варкей (2009), Симонсон (2013) нарын судалгааны үр дүнтэй нийцэж байгаа бөгөөд оюутнуудын бичгийн чадварыг бэхжүүлэх тодорхой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна. Иймд оюутнуудын бичгийн боловсролд суурилсан сургалтын

дизайн, рубрик үнэлгээг сургалтын хөтөлбөрт өргөн ашиглах, эсээ бичих сургалтыг тусгай хичээл хэлбэрээр оруулах, бичгийн материалын санг баяжуулах зэрэг саналууд дэвшүүлж байна.

Дүгнэлт: Судалгааны дүнгээс харахад оюутнуудын бичгийн харилцааны ур чадвар сул, эсээ бичих арга зүй дутмаг, дүрмийн болон найруулгын алдаа их байгааг харуулж байна. Эдгээр нь зөвхөн хэл зүйн бус мэргэжлийн боловсролын үндсэн суурь чадварт шууд нөлөөлж байна.

Санал, зөвлөмж:

1. Эсээ бичих сургалтыг тусгай хичээл хэлбэрээр оруулах
2. Рубрик үнэлгээний аргыг өргөн ашиглах
3. Жишиг эсээнүүдийн санг бүрдүүлэх
4. Сургалтад бичгийн илэрхийлэл хөгжүүлэх дасгал ажил оруулах
5. Оюутны бүтээлийг багш-сурагч хамтын шүүмжлэлд тулгуурлан сайжруулах

Ном зүй:

1. АШУУИС. Сургалтын хөтөлбөр, Харилцааны ур чадварын хичээл, 2021
2. Graham, Steve, and Michael Herbert. *Writing to Read: Evidence for How Writing Can Improve*. Carnegie Corporation Time to Act Report. Washington, DC: Alliance for Excellent Education, 2010. Carnegie Corporation, 2010.
3. Hyland, Ken. *Teaching and Researching Writing*. 4th edition Routledge 2002.
4. Varkey P, Peloquin J, Reed D, Lindor K, Harris I. Leadership curriculum in undergraduate medical education: A study of student and faculty perspectives. *Med Teach*. 2009;31:244–250
5. Simonson JA. Why we must teach written and verbal communication skills to medical students and residents. *Acad Med*. 2013 Apr;88(4):435. doi: 10.1097/ACM.0b013e3182854f57. PMID: 23531753.
6. Andrade, Heidi & Du, Ying. (2005). Student perspectives on rubric-referenced assessment. *Practical Assessment, Research and Evaluation*. 10. Practical Assessment, Research, and Evaluation, 2005.

Evaluation on students' essay writing

Oyuntsetseg S¹, Uzme M¹, Narmandakh S¹, Naranchimeg S¹

¹ MNUMS, School of Biomedicine, Department of Communication skills

Email: narmandakh@mnumns.edu.mn, Phone: 99148074

Keywords:

Communication,
assignment, template,
rubric

Background: Written communication skill is of the important skills for medical doctors and medical professionals. Written communication includes daily notes, letters, memos, personal requests, summaries, reports, editorials, and essays. An essay is a form of written assessment used by educators to make inferences about a problem, evaluate a situation, and assess their knowledge and understanding among students. Essay writing is an important tool for developing thinking, critical thinking, and analytical skills.

Aim: To do a comparative evaluation of essays by first-year students of pre-med and pre-health education

Materials and Methods: In this study, essays written on the topic “My Childhood” by students who studied Communication Skills in the 2022–2023 and 2023–2024 academic years were evaluated using the 6 criteria of the Rubric and the group discussion identified the problems students faced when writing essays.

Results: Among the essays of 568 first-year basic education students who studied in the 2022–2023 academic year, 32.6% had spelling errors, 25.5% had grammatical and composition errors, and 20.4% were insufficiently written in terms of content. It was identified that 28.6% of the essays of 525 students who studied in the 2023–2024 academic year contained spelling errors, 21.8% contained compositional errors, and 18.6% lacked content. Additionally, 10.5% did not have the required essay structure for writing their essays.

Conclusion: This indicates the need for content reforms in the curriculum to further improve students' writing skills.